


Нөхцөл байдлын ойлголт: Алдаа гарахаас зайлсхийх түлхүүр юм. 2021 оны 12-р сар



Зураг 1: Зураг дээр ослын тайлбартай холбоотой хаалтны баруулыг салгах зөв болон буруу аргыг харуулсан байна. (Эх сур. Зураг 3 CSB тайлан 2016-02-I-LA)

Хоёр оператор шугаманд дээр байрласан хавхлаганы байрлал солих даалгавартай явсан. Хавхлага нээгдэхгүй байсан учир операторууд хавхлаганы шилбэнд шууд хүрч, хавхлагыг түлхүүрээр тайлах боломжтой болохын тулд редукторыг салгахаар шийдсэн. Энэ нь ихэнх ийм төрлийн хавхлаганы дээд таганд нөлөөлөхгүй гүйцэтгэх арга байсан. Гэвч тус хавхлаганы загвар өөр байв. Операторууд уг хавхлаганаас редукторыг салган авахдаа хавхлаганы дээд тагийг бэхэлсэн боолтуудыг мөн тайлсан.

Хавхлагыг гараар нээх үед их хэмжээний уур алдагдаж, шаталт үүссэний улмаас ихээхэн хэмжээний хохирол учирсан.

Та мэдэх үү?

- Нөхцөл байдалд сонор сэрэмжтэй байна гэдэг бол хаана байгаага мэдрэх болон ажлыг аюулгүй гүйцэтгэхэд юу шаардлагатайг мэдэх явдал юм.
- Сонор сэрэмж дутах нь хүний алдаанаас үүдэлтэй осол аваар тохиолдох гол хүчин зүйл болдог.
- Ажлын тоног төхөөрөмж олон бүтцийн тохиргоотой байх нь эндүүрч будилах, ээдрээ үүсэх нөхцлийг бүрдүүлж, улмаар хэн нэгэн алдаа гаргах боломжийг хялбар болгодог.
- Хоёрдогч этгээдээр үйл ажиллагааг ажиглуулах процессыг '4-Нүдний Зарчим' гэж нэрлэдэг. Гэвч **зөвхөн** тэрхүү ажиглагч тухайн ажлыг хэрхэн гүйцэтгэхийг мэддэг **бөгөөд** ямар нэгэн алдаа эсвэл аюултай нөхцөл үүссэн үед шууд оролцох зоригтой тохиолдолд л тус зарчим хэрэгжих буюу аюулгүй ажиллагаа сайжрах боломжтой юм.
- Ажлын талбай руу явахаас ӨМНӨ ажилд бэлдэхийн тулд холбогдох журмыг унш.

Та юу хийж болох вэ?

- Ажил гүйцэтгэхийн өмнө хоёр минут хүлээх буюу "Ямар алдаа гарах боломжтой вэ?" хэмээн өөрөөсөө асуух, ажлыг аюулгүй гүйцэтгэхэд шаардлагатай журам, ХХХ, багаж хэрэгсэл байгаа эсэхийг нягтлах шаардлагатай.
- Алдаатай зүйл ажиглавал ахлах ажилтандаа мэдээлж, аюулыг тайлагнах нь зүйтэй.
- Ажигласан алдаатай зүйлийг түргэн хугацаанд засах боломжгүй бол бусад хүмүүст анхааруулахын тулд тоног төхөөрөмжид хаяг зүүж үлдээх хэрэгтэй.
- Алдаа гарахаас сэргийлэхийн тулд бүх хавхлаганы байрлал, тоног төхөөрөмжийн горим, ашиглалтын нөхцлийг ажлын журамд тодорхойлсон байх ёстой.
- Хэсэг хугацаанд хийгээгүй даалгавар авсан бол ажлын журамтай танилцаж, ямар нэгэн өөрчлөлт орсон эсэхийг лавлаж асуу.

Нөхцөл байдлын ойлголт : Үйлдэхээсээ өмнө шалга.